

## МОНГОЛД ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ ШИНЭ ШАШНЫ ХӨДӨЛГӨӨНҮҮДИЙН ГИШҮҮДДЭЭ НӨЛӨӨЛӨХ АРГА, ТҮҮНЭЭС СЭРЭМЖЛЭХ НЬ

С.Дэмбэрэл (Докторант)  
Философи, шашин судлалын тэнхим, МУИС

**Түлхүүр үг:** *Культ, шинэ шашин, гаж урсгал, ангилал, тархи угаалт, сэтгэл хянах, сэргийлэх*

**Товч утга:** *Өнөөгийн Монголын нийгэмд шинэ шашны хөдөлгөөн дэлгэрэх болсон нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал, гадаад дотоод нөхцөл шалтгаан, эдгээр шинэ шашны хөдөлгөөний олон нийтэд түгсэн нэршлийн тухай өгүүлж, Монголд үйл ажиллагаа явуулж буй шинэ шашны хөдөлгөөний жагсаалтыг гарган ангилж, тэдний олон нийтэд үзүүлж болох сөрөг тал, түүнээс урдчилан сэргийлэх арга замыг дэвшүүлэн гаргалаа. Америкийн сэтгэл судлаач эрдэмтэн Маргарет Сингерийн шинэ шашны хөдөлгөөний гишүүддээ болон олон нийтэд нөлөөлдөг сэтгэлзүйн өвөрмөц онцлог аргыг ангилж, судалсан судалгаан дээр үндэслэн өгүүллээ бичлээ.*

Социологийн сонгодог төлөөлөгчид Карл Маркс, Эмиль Дюркхейм, Макс Вебер нар шашин орчин үеийн нийгмийн янз бүрийн салбарт нөлөөгөө алдаж, шинжлэх ухаан, технологийн дэвшилд зайгаа тавьж өгөх тухай секулярчлалын онолоо дэвшүүлсэн байдаг. Гэтэл энэ онол эсрэгээрээ өнөөгийн Монголын нийгэмд хэрэгжин шашин шинэ, танигдахгүй хэлбэрээр дэлгэрэх болжээ. Шашин судлаачид даяарчлалын эринд дэлгэрч буй шашны шинэ хэлбэрүүдийг “Шинэ шашны хөдөлгөөн” гэсэн нэршил өгч судлах болжээ. Шинэ шашны хөдөлгөөн дэлгэрэх улс төр, нийгэм эдийн засгийн нөхцөл, хүчин зүйлсийг судлаачид дараахи байдлаар тодорхойлжээ. Үүнд:

1. Хүмүүс нийгмийн хурдацтай өөрчлөлтийн явцад уламжлалт ёс заншил, итгэл үнэмшилээс өөр шинэ оюун санааны арга замыг хайх болсон
2. Колончилал, коммунизмын дарангуйлал нуран унасан улс орнуудад оюун санаа, үзэл суртлын шинэ хандлага бий болох нөхцөл бүрдсэн
3. Хотжилт эрчимтэй явагдах болсон
4. Даяарчлалын эринд дэд бүтэцийн хөгжил, мэдээлэл технологийн

тусламжаар хүмүүс шашны тухай мэдээлэлийг цаг алдалгүй олж авах боломжоор хангагдах болсон

5. Даяарчлалын эринд цагаачлалын давалгаа газар авах болсоноор
6. Дэлхийн улс орнуудад эдийн засгийн өсөлт, соёлын өөрчлөлт хурдацтай өрнөж, хүмүүсийн чөлөөт цаг ихсэхийн хэрээр өөрийгөө дээдлэх оюун санааны эрэлд хүмүүс гарах болсон
7. Хүмүүс орчин үеийн завгүй амьдралын хэв маяг, сэтгэлийн дарамт шахалт, таагүй байдлыг давж гарахын тулд энэ ертөнцийн бодит байдлаас зугтах хандлага бий болсон<sup>1</sup> зэрэг шалгаан нөхцлийг дурджээ.



<sup>1</sup> John R. Hinnells, *The Routledge companion to the study of Religion*, NY, USA, 2005, page 330-331

Өнөө үед Хойд Америкд 2000, Европд 2000, Англид 700<sup>2</sup>, Өмнөд Солонгос улсад 400<sup>3</sup> гаруй шинэ шашны хөдөлгөөн байгааг судлаачид тогтоожээ.

Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй шинэ шашны хөдөлгөөний талаар Монгол улсын үндэсний статистикийн хорооны харьяа нийслэлийн статистикийн газрын 2014 оны нийслэлийн сүм хийдийн тооллогын дүнд<sup>4</sup> албан ёсны бүртгэлтэй шинэ шашны хөдөлгөөнийг “Бусад” гэсэн ангилалд оруулан 5 гэж тоолжээ. Мөн зарим шинэ шашны хөдөлгөөний ангилалд багтдаг шашны урсгалыг “Христийн шашин” гэсэн ангилалд оруулсан байна. Үүнээс үзвэл Монголд буй шинэ шашны хөдөлгөөний статистик тоо баримтыг гаргахдаа шинэ шашны хөдөлгөөнийг буруу ангилсан, статистик тоо баримт нь зөрүүтэй байгааг харуулж байна. Мөн Монгол улсын сүм хийд, шашны байгууллагын статистик тоо баримтад шинэ шашны хөдөлгөөний тоо зөрөөтэй байгаа нь шинэ шашны хөдөлгөөний өөрсдийн үйл ажиллагаагаа олон нийтийн, төрийн бус байгууллагын халхавч дор явуулдагтай холбоотой байж болно. Албан бус тоо баримтаас үзэхэд Монголд зөвшөөрөлтэй, зөвшөөрөлгүй 50 орчим шинэ шашны хөдөлгөөн үйл ажиллагаа явуулж буй мэдээ байна.

**Шинэ шашны хөдөлгөөн үү? Культа/гаж урсгал/ уу?** Энэ нэр томъёог хэрэглэх өөр өөр чиг хандлагууд байна. Цахим орчинд гүүгл хайлтийн системээс шинэ шашны хөдөлгөөн (new religious movement<sup>45</sup>) хэмээн хайхад культэд багтдаг шашны урсгал чиглэлүүд гарч ирж байгаа бол, Культа (cult<sup>6</sup>) хэмээн хайвал мөн ШШХ-нд хамаарах шашны урсгалууд гарч ирж байгаа нь эдгээр шашны урсгалд судлаачид, олон нийт янз бүрийн байр сууринаас хандаж буйг илэрхийлнэ. Тэдний чиг хандлагыг ангилбал:

- Академик түвшинд судлаач эрдэмтэд 1960 оноос хойш голчлон “Шинэ

шашны хөдөлгөөн” гэсэн нэр томъёог хэрэглэж байна. Зарим гадаадын сэтгэл судлаач эрдэмтэн культа гэх нэр томъёог бүтээлдээ дурджээ.

- Хэвлэл мэдээлэлийн түвшинд голдуу Культа/гаж урсгал/ гэх нэр томъёог хэрэглэж байна
- Тухайн шашны урсгалд явж байсан хуучин гишүүд, хохирогчид, тэдний гэр бүл, гажурсгалын эсрэг хөдөлгөөнийхөн культа гэх нэр томъёог өргөн хэрэглэж байна.
- Мөн Христийн шашны гол сүм хийдүүд, цуглаан тус шашны урсгалыг культа гэх нэр томъёогоор тодорхойлох нь элбэг байна.

Монголын шашин шүтлэгийн нөхцөлд байдалд судлаачид, шашны байгууллагууд тал бүрээр үнэлэлт өгч байна. Монголын шашин судлаач эрдэмтэн С.Цэдэндамба, А.Жамбал, Ж.Алтайбаатар нар шинэ шашны хөдөлгөөнийг Монголд буй уламжлалт бус шашны ангилалд хамааруулж “Шинэ шашны хөдөлгөөн” гэх нэр томъёог өөрсдийн эрдэм шинжилгээний бүтээлүүддээ өргөн хэрэглэжээ.

Харин Монголын Эвангелийн эвслээс “Таж буруу урсгалууд” товхимолыг гаргаж, Монголд үйл ажиллагаа явуулж байгаа болон цаашид орж ирж болзошгүй зарим шинэ шашны хөдөлгөөний талаар бичсэн бөгөөд тэдгээрийг “таж” хэмээн тодорхойлсон байдаг.

Шинэ шашнууд ихэнхдээ дэлхийн аль нэг томоохон шашны үзэл номлолыг гуйвуулан явцуу хүрээний эрх ашгийг хамгаалдаг сул талтай. Тиймээс ч “таж” гэж нэрлэгддэг. Ялангуяа өөртөө шинэ гишүүн элсүүлэхийн тулд одоогийн нийгмийн байдалд зохицуулж, шашны үндсэн утга санааг нь алдагдуулж, улмаар төрөл бүрийн арга замаар хүрээгээ тэлдэг онцлогтой. Тийм шинэ шашнуудын тоонд, тухайлбал:

**Америкаас үүсэлтэй шинэ шашны хөдөлгөөнүүд:**

1. Еховагийн гэрчүүд<sup>7</sup>, /XIII хороолол/
2. Мормон<sup>8</sup> /Хожмын үеийн

<sup>2</sup> Мөн тэнд

<sup>3</sup> Andrew Eungi Kim, Characteristics of religious life in South Korea: A Sociological Survey, Korea University, Review of Religious Research, 2002, volume 43:4, page 293

<sup>4</sup> <http://sumhiid.ubstat.mn/Report.aspx>

<sup>5</sup> Шинэ шашны хөдөлгөөний гүүгл хайлтын дүн ойролцоогоор 12,900,000 илэрц (0.30 секунд) гарч байна

<sup>6</sup> Культа буюу гаж урсгалын гүүглийн хайлт ойролцоогоор 166,000,000 илэрц (0.37 секунд) гарч байна

<sup>7</sup> Jehovah's Witnesses, [https://en.wikipedia.org/wiki/Jehovah's\\_Witnesses](https://en.wikipedia.org/wiki/Jehovah's_Witnesses)

<sup>8</sup> Mormons <https://en.wikipedia.org/wiki/Mormons>

гэгээнтнүүдийн сүм/, (УБ-д 6 сүмтэй)

3. Долоо дахь өдрийн Адвентист<sup>9</sup>, /Х хороолол, III эмнэлэгийн төв байр, Лениний Музейн хойно 4 давхар цагаан байр/
4. Сайентологи<sup>10</sup> /боловсролын байгууллагын нэрээр халхавчлан Монголд сургалт явуулсан мэдээ байдаг/

**Солонгосоос үүсэлтэй шинэ шашны хөдөлгөөнүүд:**

1. Мүүний эв нэгдлийн сүм, дэлхийн энх тайвны хөдөлгөөний итгэлийн нийгэмлэг, /Дэлхийн энх тайвны гэр бүлийн холбоо, Дэлхийн Оюутны энх тайвны холбоо, XIII хороолол дахь бөхийн өргөөний орчим, Эрдэнэт хот /
2. Бурханы цуглааны Ан Санхуны гэрчлэлийн нийгэмлэг, (Ээж бурхан) /Сансар дахь Торнадогийн ойролцоо барилгын 2 давхарт цугладаг/
3. Берой урсгал-Солонгосын Иерусалим цуглаан /И Чусог/ (Налайх орох замд олон гэр барьж гэр бүлийн амьдралаар амьдарч байгаа, Циркэд том ү/а зохион байгуулсан)
4. Рема авралын зарын нийгэмлэг (И Мёнбом) Ель цуглаан ЧД ҮИ хорооны 54-р байрлуу нүүсэн /Үүрдийн гэгээ цуглааны нарийн гудамж/
5. Авралын урсгал /Гвон Шинчан, И Иохан, Пак Угсү/ Улаанбаатар, Москва хороолол дахь “УБ төв баптист цуглаан” 250 орчим хүн цуглардаг, Говь сауны эсрэг талд “УБ цуглаан” Борнуур, Хөвсгөл аймагт цуглаантай
6. Перуиа урсгал-Перуиа академи /Ким Гидун/
7. Эчонь цуглаан /Жон Мён Сог / (JMS)
8. Гэмшлийн 4 үе шатны онол /Пак Мүсү/
9. Авралын зар тараах нийгэмлэгийн

урсгал-Халлелүяа залбиралын өргөө /Ким Гэхуа/

10. Авралын зар тараах нийгэмлэгийн урсгал- Мөнхийн амийн шашин /Жу Хи Сон/
11. Манжин Жун - Ан цуглаан (И Жэруг)
12. Удмын хараалын онол (И Юнху)
13. Дээврийн өрөөний авралын зар тараах хөдөлгөөн (Рю Гуансү)
14. Бурханы өвийг хамгаалах нийгэмлэг (И Сон У)
15. Шинэ тэнгэр, Шинэ газар цуглаан (Үнэгүй Библийн сургалтын дамжаа явуулдаг, үндэслэгч нь И Манхи)

Дээр дурдсан гаж урсгалын(культ)<sup>11</sup> ихэнхи нь Америк болон Солонгосын христийн шашны протестант урсгалаас салж гарсан, шашны номлол түгээгчдийн идэвхтэй үйл ажиллагааны үр дүнд дэлгэрсэн буюу дэлгэрэх төлөвтэй байна. Солонгосын Католик их сургаалийн судлаач Воо Хай-ран солонгосын шинэ шашны хөдөлгөөн үүссэн үеийг таван түүхэн үечлэлд хувааж үзсэн байдаг. Үүнд:

- Солонгос улсын гадаадын улс орнуудад нээлттэй болсон үе (1860-1910)
- Японы колончлолын доорхи үе (1911-1945)
- Үндэсний эрх чөлөөгөө олсоны дараахи үе (1946-1960)
- Аж үйлдвэржилтийн үе (1961-1980)
- Аж үйлдвэржилтийн дараахи үе (1981-өнөө үе) болно.<sup>12</sup>

Солонгос улсаас Монголд улсад орж ирэн үйл ажиллагаа явуулж буй дээр дурдсан культ буюу шинэ шашны хөдөлгөөнүүд нь ихэвчлэн Солонгосын үндэсний эрх чөлөөгөө олсоны дараахи үе, аж үйлдвэржилтийн үе болон түүнээс хойш үүссэн байна. Солонгосчууд 1945 онд үндэсний эрх чөлөөгөө олсоноор

<sup>11</sup> Эдгээр гаж урсгалын жагсаалтыг Монголын Эвангелийн Эвсэлээс гаргасан “Гаж Буруу Урсгалууд” УБ хотод 2013 онд хэвлэгдсэн товхимолоос авав.

<sup>12</sup> WOO Hai-Ran, Catholic University of Korea, “New Religious Movements in South Korea focused on Contemporary Situation” which was presented at the 2010 International Conference of Korean Academy of New Religions, held at the school of Theology at Claremont in California, USA, page 2

<sup>9</sup> Seventh-day Adventist Church [https://en.wikipedia.org/wiki/Seventh-day\\_Adventist\\_Church#Exclusivism](https://en.wikipedia.org/wiki/Seventh-day_Adventist_Church#Exclusivism)

<sup>10</sup> Scientology <https://en.wikipedia.org/wiki/Scientology>

Америкийн нөлөөн дор шашны эрх чөлөөг тунхаглан, төр сүм хийдийн харилцааг зааглан, шашны байгууллагуудын хооронд чөлөөт өрсөлдөөн бий болгосон, гадаадын хүчнүүдийн Солонгосд нөлөөгөө тэлэх гэсэн бодлого, солонгосын иргэний дайн, нийгэм, улс төрийн тогтворгүй байдал нь шинэ шашны хөдөлгөөнүүд үүсэх нөхцөлийг бүрдүүлжээ. Тэдгээр шинэ шашны хөдөлгөөн нь:

1. Солонгосын уламжлалт Бөө мөргөл, Буддизм, Күнз, Даогийн сургаальтай Христийн номлол сургаалтай холилдож синкретик шинж чанартай болсон
2. Эдгээр шашнууд ертөнцийн төгсгөл ирж түүний дараа шинэ эрин ирж, эх амгалан тогтоно гэж амладаг
3. Шинэ эринд тухайн шашныг үндэслэгчээс өөр хэн ч та бүхнийг аврахгүй гэж номлоно.
4. Ихэнхи шинэ шашны хөдөлгөөн нь Солонгосын үндэсний ухамсарыг сэргээж Солонгос орон, ард түмэн л эзэн тэнгэрийн сонгогдсон ховор хувь заяатай хэмээн номлодог. Эдгээр онцлог шинж чанаруудыг Солонгосын их сургуулийн профессор Андрей ЕунгиКимөөрийн “Өмнөд Солонгосын шашны амьдралын өвөрмөц шинж чанарууд: социологийн судалгаа”<sup>13</sup> өгүүлэлдээ ангилж, дурджээ.

Дээр дурдсан Солонгос улсаас орж ирсэн зарим шинэ шашнуудын онцлог шинж чанарууд болон тэдний явуулж буй үйл ажиллагааг тандахад тухайн шашны үндэслэгчийг дээдлэн тахин шүтэх, солонгос хүн, солонгос соёлыг дээдлэх үзлийг Монголд дэлгэрүүлэх, олон нийтийг шашин шүтлэгээр нь хагалан бутаргах, Монголын түүх соёл, уламжлалаас нь хөндийрүүлж, монгол хүний өөрсдийн онцлог тал, үнэлэмжийг бууруулж болох тал ажиглагдана.

**Дорно дахинаас гаралтай Шинэ шашны хөдөлгөөн, урсгалууд ч бас монголд үйл ажиллагаа явуулах болжээ.** Гэхдээ тэдний үйл ажиллагааны онцлогоос

харвал гаж гэхээсээ илүү “шинэ” гэсэн ангилалд хамруулж болох юм. Тэд ихэвчлэн бясалгалын төвийн үйл ажиллагаа явуулдаг, хувь хүний оюун санаа, стрессээс гарах, зөв амьдрах арга замыг заадаг. Монголын нийгэмд үзүүлэх сөрөг нөлөө нь бага байж болох ч, цаашид нарийвчлан судлах шаардлагатай. Үүнд:

1. Монгол дахь Ошо Бясалгалын Төв Утас: 99530513, 99209835 [https://www.facebook.com/OshosMongolia/info?tab=page\\_info](https://www.facebook.com/OshosMongolia/info?tab=page_info)
2. Чинадаас халих бясалгалын төв, Махариши багш Transcendental meditation center /1-р төрөхийн урд Фламинго цамхаг, 5-р давхар /<https://www.facebook.com/TMMongolia/info?tab=overview>
3. Рейки бясалгалын төв
4. Олон улсын Кришнагийн ухамсарын нийгэмлэг (ISKCON) /Улаанбаатар хот дахь Ведийн соёлын төвийн хаяг: Сансрын шатахуун түгээх станцаас хойш Дарь-эх өөд эргээд 200 м орчимд замынхаа зүүн талд байрлах 2 давхар ягаан байшин Харилцах утас: 99786426, 98663058, 99756136 86468336, 98657256/ [http://www.veda.mn/component/option.com\\_contact/catid.12/Itemid.63/](http://www.veda.mn/component/option.com_contact/catid.12/Itemid.63/)
5. Японы Ничерин буддын Сока Гаккай байгууллага [https://en.wikipedia.org/wiki/Soka\\_Gakkai#Cult\\_appellation](https://en.wikipedia.org/wiki/Soka_Gakkai#Cult_appellation)
6. Японы иргэн Рюхо Окавагийн үндэслэсэн “Happy Science”/Аз жаргалын шинжлэх ухаан/ төв / Мөнхийн хууль, оюун ухааны 9н ертөнцийн нууцыг тайлахуй зэрэг номнууд нь Монголд хэвлэгдсэн/ үйл ажиллагаа нь дөнгөж эхэлж байгаа [https://en.wikipedia.org/wiki/Happy\\_Science](https://en.wikipedia.org/wiki/Happy_Science)
7. Тэндоу төв, бясалгал, мэлмий нээх зан үйл явуулдаг, /Япон, Тайваны бясалгал, йог, хэлний сургалтууд явуулдаг /Гандан хийдийн урд Их хүрээ хийдэд байр түрээслэж үйл ажиллагаа явуулдаг/ <http://mgltendou.blogspot.com/?view=classic>
8. Оомото төв /Японы шинто шашны

<sup>13</sup> Andrew Eungi Kim, Korea University, “Characteristics of Religious life in South Korea: A social survey”, Review of Religious Research, 2002, Volume 43:4, pages 291-310

шинэ урсгал/ <http://www.oomoto.or.jp/Mongolian/innKyos/kyosm-mn.html>

Монголд үйл ажиллагаа явуулж буй шинэ шашны хөдөлгөөнүүдийг үүссэн газарзүйн байрлалаар нь ангилбал:

- Өрнийн Христийн шашнаас салбарлан гарсан шинэ шашны хөдөлгөөнүүд,
- Дорно дахины бөө мөргөл, хиндүизм, буддизм, даогийн шашнаас үүссэн шинэ шашны хөдөлгөөнүүд хэмээн ялгаж болно. /Сүүлийн үед Монголд уламжлалт байгаль шүтлэг, бөө мөргөл, өвөг дээдэс, хаадыг хүндэтгэн шүтэх үзлийг номлосон шинэ шашны хөдөлгөөн үүсэх хандлага ч ажиглагдах болжээ./

Дээр дурдагдсан шинэ шашны хөдөлгөөнд харьяалагдах шашны байгууллага, бүлэг, цуглаан, төвүүд нь:

- Уламжлалт шашнаас салж гарсан байхаас гадна, өөрсдийн удирдагчдыг дээдлэн тахин шүтэж, тэднийг тойрсон явцуу бүлэглэл, хүрээлэл үүсгэдэг.
- Харь шашин, соёлоос гаралтай, тухайн шашны төлөөлөгчид болон тэднийг дэмжигч Монгол иргэдийн дэмжлэгээр үйл ажиллагаа явуулдаг.
- Олон нийтийн, сайн дурын байгууллагын хүрээнд хувь хүний төлөвшилийн чиглэлээр сургалт явуулдаг ч, сургалтын хөтөлбөр, үзэл санаа нь шашны номлол дээр суурилдаг. /Сайентологи/
- Зөв амьдрах ухаан, бясалгалыг зааж сургах үйл ажиллагаа эрхэлдэг ч үйл ажиллагааны үндсэн үзэл санаа нь ямар нэг шашны номлол сургаал дээр тулгуурладаг гэх мэт үүсэл гарал, үйл ажиллагааны хувьд харилцан адилгүй онцлогтой байна.

Барууны улс орнуудад дээр нэр дурдагдсан сүм цуглааныг теологчид, христийн шашны номлогчид, эдгээр сүмд явж байсан хуучин гишүүд, хэвлэл мэдээлэлийнхэн гаж урсгалын эсрэг иргэний нийгмийн хөдөлгөөнүүд, зарим судлаачид “культ” хэмээн нэрийддэг байна.

Культ нь ихэвчлэн уламжлалт шашны ариун номлол сургаалийг гажуудуулж, шинэ

номлолыг дэлгэрүүлсэн хувь хүнийг тахин шүтэж, сүм цуглаанаа шууд захиргаадалт, дарангуйлалын хэлбэрээр удирддаг ажээ. Мөн нийгэмд хүлээн зөвшөөрөгдсөн уламжлалт соёл, тогтсон хэм хэмжээ, үнэт зүйлээс гажсан зан үйл, үйл ажиллагаа явуулдаг учраас “аюултай, захиргаадагч шашны бүлэг”<sup>14</sup> гэсэн тодорхойлолтыг зарим судлаачид<sup>15</sup> өгсөн байна.

Шашин судлаачид болон социологчид эдгээр шинэ шашны хөдөлгөөн /культ/-ийг нийгэмд явуулж байгаа үйл ажиллагаагаар нь идэвхтэй, идэвхгүй гэж ангилахаас гадна Белфастийн Хатан хааны их сургуулийн социологч эрдэмтэн Рой Валлис<sup>16</sup> шинэ шашны хөдөлгөөнийг нийгэмд үзүүлэх нөлөө, байр сууриар нь дараахи гурван янзаар ангилжээ. Үүнд:

- Энэ ертөнц, *нийгмийн амьдралыг дэмждэг* шинэ шашны хөдөлгөөн / дагалдагчдынхаа шашинлаг, сүнслэг чадварыг нэмэгдүүлж ажил амьдралдаа амжилт гаргахыг дэмждэг /
- Энэ ертөнц, *нийгмийн амьдралыг үгүйсгэдэг* шинэ шашны хөдөлгөөн / энэ нийгмийн амьдралыг шүүмжилж, үгүйсгэн дагалдагчдаа нийгмийн амьдралаас хөндийрч, өөрсдийн шашны номлол сургаалийн дагуу тухайлсан амьдарлын хэв маягаар амьдрах, ямар хоол, хувцас хэрэглэхийг нь заадаг/
- Энэ ертөнц, *нийгмийн амьдралд зохицдог* шинэ шашны хөдөлгөөн / Хувь хүн дотоод итгэл үнэмшлээ энэ ертөнцийн асуудлаас илүүд авч үзэхийг заана. Гишүүд нь уламжлалт шашнууд сүнслэг, оюун санаалаг ариун чанарыг гээсэн гэж үздэг/

Шинэ шашны хөдөлгөөнийг нийгэмд ихэвчлэн сөрөгөөр хүлээн авдаг нь энэ шашны номлол сургаал, зан үйл, /дахин амилуулах оршуулга, гишүүдээ ваакум орчинд оруулж нийгмээс тусгаарлах, олноор нь гэрлүүлэх, эх орноо хамгаалахаас зайлсхийлгэх, төрийн сүлд туг, далбаанд хүндлэл үл үзүүлэх, нийтээр тэмдэглэдэг баяр ёслолыг үл хүндлэх, аминд тулсан үед

<sup>14</sup> <http://www.icsahome.com/articles/onusingtermcult>

<sup>15</sup> Robbins, T. (1988). Cults, converts, and charisma. London, England: Sage Seventh-day Adventist Church#Exclusivism

<sup>16</sup> [https://en.wikipedia.org/wiki/Roy\\_Wallis](https://en.wikipedia.org/wiki/Roy_Wallis)

өвчтөний цусыг үл солиулах, бөөнөөр амиа хорлоход уриалах зэрэг/ үйл ажиллагаа нь тухайн улс орны түүх, соёл, уламжлал, нийгмийн тогтсон хэм хэмжээ, үнэт зүйлээс тэс ондоо, шинэлэг, заримдаа гаж буруу мэт харагдах байдлаас үүдэлтэй.

Барууны шашин судлаач Жон Салиба<sup>17</sup>, сэтгэл судлаач М.Сингер<sup>18</sup>, Майкл Д.Лангоне<sup>19</sup> нар культ (шинэ шашны хөдөлгөөний) сөрөг номлол, үзэл санаа, зан үйл, үйл ажиллагаанаас иргэдээ сэрэмжүүлэх үүднээс олон судалгаа хийж, судалгааны үр дүнгээ ном болгон хэвлүүлж, бичлэг хийж youtube-д<sup>20</sup> байрлуулжээ.

Америкийн Калифорнийн их сургуулийн профессор Маргарет Сингер агсаны культурын (шинэ шашны хөдөлгөөний) гишүүдийнхээ бодол санаанд нөлөөлж, тэднийг өөрчилдөг 6 онцлог шинж, арга, нөхцөл байдлыг дараахи ангилалаар тодорхойлсоныг дэлгэрүүлж, тайлбарлан жагсаавал:

### 1. Шинэ шашны хөдөлгөөний гишүүд ихэвчлэн зальжин аргаар шинэ гишүүд элсүүлнэ. /Deception/

- Шинэ шашны хөдөлгөөн нь маш олон холбоо, нийгэмлэг, сан, төрийн бус байгууллагын нэрээр халхавчлан үйл ажиллагаагаа явуулдаг. Өөрсдийн байгууллагын нэрийг “Хувь хүний хөгжлийн төв”, “Оюуны хөгжлийн төв”, “Номын нөхөр бүлэг”, “Дэлхийн энх тайвны байгууллага”, “Архи тамхинаас гаргах төв”, “Хүмүүнлэгийн байгууллага” гэх мэтээр танилцуулна.
- Өөрсдийн номлол сургаал, зорилго, чиглэлийг шууд хэлэхгүй тусгай мэдлэг, чадвар олгох яриа, лекц, сургалт зохион байгуулж байгаа гэж хуурна
- Улс төрч, нийгмийн зүтгэлтэн, урлаг, спортын ододыг хүлээн авалт, баяр ёслолын арга хэмжээнд урьж, эгнээндээ элсүүлэн хожим тэднийг үйл

ажиллагаагаа сурталчлахад ашигладаг.

- Үнэгүй цай, кофе, хоолонд урьж, аялал зугаалганд хамт явахыг санал болгоно.
- Хүний эмзэг талыг мэдэрч “сайн ах, эгч, найз”-ын дүрд тоглон “Хайр энэрэл, өгөөмөр сэтгэл, магтаалын үгээр бөмбөгдөж “зөөлөн аргаар” бүлэгтээ татна.
- Хүмүүсийг голдуу амьдралын бэрхшээлтэй тулгарч, ганцаардаж, зовж шаналсан үед нь элэгсэг, энэрэнгүй дотно сэтгэлд дулаан үгээр хуурч, танд нэг л олодох боломж хэмээн хурдан шийдвэр гаргуулж сүмдээ элсүүлэхээр шамдаж, ятгана. Культэд голдуу тэнэг, гаж сэтгэлгээтэй, хачин жигтэй зүйлд сонирхолтой этгээд хүмүүс элсдэг гэж бодож болохгүй. Культуын гишүүд бидний итгэдэг, хүмүүст нээлттэй ханддаг ойр дотны найз нөхөд, гэр бүлийн гишүүдийг ч хуурч элсүүлж амждаг.
- Зарим тохиолдолд тусгай мэргэжлийн хүмүүс тухайлбал багш, эмч, сувилагч, сэтгэлзүйчдийг бүлэгтээ элсүүлж, тэднээр дамжуулж, өвчтөн, үйлчлүүлэгчдийг нь татах оролдлого хийдэг.

Тиймээс ямар нэг шашны байгууллагад элсэхээсээ өмнө бусдын үгэнд хууртаж, мухар сохроор аялдан дагалдаж, сэтгэл хөдлөлдөө авталгүй түүний тухай маш сайн судалж, үнэлэлт дүгнэлт хийж, гарах үр дагаварыг нь тооцоолно уу.

Ер нь шинэ шашны хөдөлгөөний энэ төрлийн тусгай үйл ажиллагааг хүмүүс, нийгэмд хандсан, олон нийтийн үйл ажиллагаа явуулж байна хэмээн эндүүрч олноороо хамрагдах нь элбэг байдгийг сэрэмжлүүштэй.

### 2. Шинэ гишүүдийг нийгмээс нь салгаж, өөрчлөхийг оролддоно. /Destabilization/

- Тухайн хүний сул талыг харилцан ярилцаж, асуулт тавих, анкет бөглүүлэх аргаар мэдэж авна.
- Энэ нийгэм харанхуй бүдүүлэг, шударга бус, чөтгөр шулам, сатаны хорлол болсон гэж итгүүлнэ
- Сүмийн гишүүдээ ариун, гэгээрсэн,

<sup>17</sup> Saliba, John A., Understanding New religious Movements, 2nd ed. (Walnut Creek, Calif: Alta Mira Press, USA 2003)

<sup>18</sup> Margaret Thaler Singer PhD, /Clinical psychologist/ Prof at University of California, Berkeley, "6 Conditions for a thought reform environment" <https://www.youtube.com/watch?v=8bRBFhMEQFk> Singer, M T, Cults in our midst: The Hidden Menace in our Everyday Lives, San Francisco, CA: Jossey Bass, USA, 1995

<sup>19</sup> <http://www.icsahome.com/articles/characteristics>

<sup>20</sup> <https://www.youtube.com/watch?v=8bRBFhMEQFk>

эзэн тэнгэрийн авралд ойрхон хэмээн итгүүлж бусдыг буруу номтон, чөтгөр сатантай зүйрлэж ойлгуулдаг.

- Хувь хүнийг гэр бүл, найз нөхдөөс нь холдуулж, ахуй орчныг өөрчлөн сүмийн гишүүдийн хүрээлэлд авч, зарим тохиолдолд өмсөх хувцас, идэх хоолыг нь зааж “бодох сэтгэх цагийг” нь хянана. Унтах, амрах цаг өгөхгүй байнга культийн /гаж урсгалын/ үйл ажиллагаа, номлол сургаалдаа оролцуулж завгүй, ажилтай байлгадаг.
- Гаж урсгалын талаархи мэдээлэлээр бөмбөгдөж, бусад гадны мэдээлэлийн эх сурвалжийг хаана.
- Бие биенээр нь тагнуул туршуул хийлгэн, алдаан дээр нь дөрөөлж хяналтандаа авахаас гадна, удирдагчаа далдыг мэддэг ер бусын чадвартай гэдэгт итгүүлнэ.
- Шинээр элссэн гишүүний асууж лавлах, тэдний номлол сургаал, үйл ажиллагаанд шүүмжлэлтэй хандах тохиолдолд сүм дотор нь ганцаардуулан сэтгэл санаагаар унагаж, бусад бүх гишүүдийн өмнө гэмтэн болгодог байна. Хүний эргэлзэх, логик, шүүмжлэлт сэтгэлгээ, үг хэлэх эрхийг боогдуулж, удирдагчийн хэлсэн болгоныг үг дуугүй дагадаг болгож хувиргана.

### **3. Гишүүдээ байнга удирдагчаасаа хамааралтай байлгаж, айлгах арга хэрэглэнэ./Dependency and dread/**

- Удирдагч нь өөрийгөө шашны ариун сударт заасан зөнч мэргэн “элч” гэж гишүүддээ итгүүлэн үг дуугүй номлолыг нь дагахыг шаардана.
- Зарим культын удирдагч нь өөрийгөө гэгээрсэн их багш, ер бусын чадвартай, харь гаригийнхантай холбогдох чадвартай гэж өргөмжилнө.
- Шинжлэх ухааны нэр барьсан хуурамч туршилт явуулж номлол, зан үйлээ аврал/гэгээрлийн хамгийн шилдэг арга хэмээн итгүүлж, эргэлзээгүй дагахыг шаардана. Тэд номлол сургаалдаа Чарльз Дарвин, Карл Маркс, Зигмунд Фрейд, Макс Вебер гэх мэт сэтгэгчид, эрдэмтэдийн

үзэл онолыг ашиглан итгэгчиддээ бид тэдний дэвшилтэт сэтгэлгээ, зам мөрөөр явж буй хэмээн ухуулдаг.

- Удирдагчид нь гишүүдээ сэтгэл хөөрөл, транс-д оруулах, ховсдолт, hyperventilation/ойр ойрхон амьсгалах, гүн амьсгалах, уушгаа хүчилтөрөгчөөр дүүргэх/ аргыг хэрэглэн өөрийн үгийг үг дуугүй дагадаг болгоно. Тэд өөрсдийн үг яриа, шившлэг, дуу, мөргөл залбирал, бясалгал, өөрийн түүх дурсамжийг байнга давтан гишүүдийн сэтгэлд хий дүрслэл бий болгож, өөрсдийн эрхшээлд оруулдаг.
- Тухайн хүнийг өөрийн гэсэн бодолгүй, удирдагчаасаа хараат, хүчгүй, сул дорой, айдасын байдалд оруулна

### **4. Гишүүдийг хуучин амьдарлын хэв маягаас нь салган зан чанар, үзэл бодол, чиг хандлагыг өөрчлөхийг оролдоно. / Disconnection/**

- Шинэ гишүүний урд өмнөх амьдрал утга учиргүй, сэтгэл минь хорон санаагаар дүүрэн байсан гэдгийг хүлээн зөвшөөрүүлж, урдын амьдралыг нь хар өнгөөр будаж, элэг доог болгон доромжилж, хуучин амьдралын хэв маяг, зуршлаа орхин шинэ хүн болох ёстой гэж итгүүлнэ.
- Амьдралд нь тохиолдсон урдын гэмт явдал, тэр байтугай дотоод сэтгэлдээ бодож явдаг/далд ухамсарт байдаг/ бодол, зүүдийг нь хүртэл бичүүлж гэм нүгэлтэн байсан гэж итгүүлж, байнга наминчлуулна.
- Гаж урсгалын гишүүд нь этгээд хэллэг, нэр томъёог бий болгож өөрсдийн хэлээр харьцдаг. Тэд өөрсдийгөө шинэ гишүүдэд тусгай мэдлэг чадвартай гэж итгүүлэхийн тулд ийм нэр томъёо, этгээд хэллэгийг бий болгодог. Мөн эдгээр этгээд хэллэгийг гэрийн тэжээвэр нохойг сургаж номхруулах команд үгтэй адил шинэ гишүүдийг тэдний эрхшээлд оруулахад хэрэглэнэ.
- Гишүүдээ шинэ сүмийн гэр бүл, удирдагчийг үргэлж хүндлэн шүтэж, сайн гишүүн болохыг үргэлж тэдэнд сануулж, шагнал болон шийтгэлийн аргыг хэрэглэн тэднийг номхон

дуулгавартай болгоно.

- Гишүүдээ байнга хийсэн үйлээ наминчлахыг шаардаж, тэдний сул талтай холбоотой мэдээлэлийг наминчлах үед нь олж авч, тэднийг номхон хүлцэнгүй дуулгавартай болгоход ашигладаг.

### 5. **Культгийн хэм хэмжээнд тохирсон ёс журмыг дагахыг гишүүддээ шаардан шинэ зан чанар, үзэл бодол, хандлагатай хуурамч хувь хүн болгон хувиргадаг. / Developing the cult pseudo-personality/**

- Зарим тохиолдолд гишүүддээ шинэ нэр өгч, шинэ хүн болгох зан үйл хийнэ.
- Номлол сургаалаа тусгай шинэ нэр томъёогоор зааж, түүнийг ойлгож, сэтгэж, амьдралдаа хэрэгжүүлэхийг шаардана.
- Гишүүдийг культурын номлол сургаал, үзэл номлолыг дагасан хуурамч хувь хүн болгон хувиргана. Тэд культурын үйл ажиллагаа, санхүүг дэмжихийн тулд гудамжнаас "архи, тамхинаас гаргах төв, асрамжийн газарт хандив цуглуулж байна" гэж хүмүүст худлаа хэлж мөнгө цуглуулдаг. Тэд хүмүүсийг өөрсдөөс нь муу хувь заяатай, номлол сургааль ойлгодоггүй гэж үзэн тэдэнд худлаа хэлж болно гэж үздэг.
- Культурын гишүүд хоорондоо энгийн хүнд ойлгогдохгүй тусгай нэр томъёо, хэллэгээр харилцана.
- Бидний номлол, зан үйл онцгой ер бусын гэж итгүүлж, дадуулна.
- Тусгай мөргөл унших, бүжиглэх, эргэлдэх, амьсгалаа түгжих, хэт амьсгалах, бясалгах, транс, ховсын байдалд оруулах аргыг хэрэглэнэ.

### 6. **Явцуу хаалттай хүрээнд сэтгэж, бие сэтгэлээ культдээ зориулахыг шаардана./Denial and dedication/**

- Номлол сургаалдаа чөлөөт, шүүмжлэлтэй, логик сэтгэлгээгээр хандахыг хязгаарлана.
- Бусдын итгэлд үнэмшлийг доорд үзэж, өөрсдийн итгэл үнэмшлийг төгс дээд гэх үзэл баримтална.
- Удирдагч нь байгаль, нийгмийн гамшигт үзэгдлийг жишээ татан номлол сургаалыг

дагахгүй бол тэр мэт цээрлэл хүлээнэ гэж сүрдүүлнэ.

- Удирдагч нь зарим тохиолдолд "ертөнцийн төгсгөл" гэх мэт ирээдүйд болохыг зүйлийг урьдаас зөнчлөн хэлж, биелээгүй тохиолдолд гишүүдээ номлол сургаалыг нь үнэнчээр дагаагүйгээс боллоо гэж буруутган, ирээдүйд болох зүйлийн хугацааг нь хойшлуулж сунган, гишүүдээ улам илүү дуулгавартай байж, номлол сургаалыг нь дагахыг шаардана.
- Культээс гарах иргэдийг чамд удахгүй өвчин зовлон, гэнэтийн золгүй явдал тохионо, замаасаа няцлаа, буцаж муу замдаа орлоо гэж буруутгаж сүрдүүлнэ.

Дээр дурдсан шинэ шашны хөдөлгөөний гишүүддээ нөлөөлөх арга барил, үйл ажиллагаа нь зарим шинэ шашны хөдөлгөөнд харилцан адилгүй илэрч болох талтай. Сэтгэл судлаач Маргерет Сингер шинэ шашны хөдөлгөөний номлол сургаал, үйл ажиллагааны онцлог шинжийг ангилж дурдахдаа голчлон хувь хүний тархийг угаах, сэтгэл санааг хянах, оюун санааг явцуу хүрээнд оруулах зэрэг сөрөг нөлөөг дурдсан байна. Түүнээс гадна Маргерет Сингер америкийн сэтгэл засалч Роберт Липтоны<sup>21</sup> культуудын өөрсдийн гишүүдийн *сэтгэлд нөлөөлдөг найман дэлгэрэнгүй хэв шинж*, сэтгэл судлаач Эдгар Шайны<sup>22</sup> культурынхан гишүүддээ *сэтгэлзүйн хувьд өөрчилдөг гурван үе шатыг* шашин судлаач Лорне Давсоны эмхэтгэсэн "Кульг ба шинэ шашны хөдөлгөөн"<sup>23</sup> номын тавдугаар бүлгийн "Тархи угаах, сэтгэлзүйн албадлага ба бодол санааг өөрчлөх үйл явц" нийтлэлдээ дурджээ.

Шинэ шашны хөдөлгөөнүүдийн уламжлалт шашнаас ялгагдах онцлог нь:

1. Итгэл үнэмшлийн хувьд тэд ихэвчлэн тус хөдөлгөөнийг үндэслэгч, удирдагчидаа ариун, ер бусын чадвартай хэмээн үг дуугүй тахин шүтнэ. Тэдний заасан номлол сургаалыг туйлын үнэнд тооцож итгэнэ.

<sup>21</sup> [https://en.wikipedia.org/wiki/Robert\\_Jay\\_Lifton](https://en.wikipedia.org/wiki/Robert_Jay_Lifton) Lipton R, Thought Reform and the Psychology of Totalism, New York, USA, 1963

<sup>22</sup> [https://en.wikipedia.org/wiki/Edgar\\_Schein](https://en.wikipedia.org/wiki/Edgar_Schein)

<sup>23</sup> Lorne L. Dawson, Cults and new religious movements, a reader, Blackwell publishing Ltd, MA, USA 2003



2. Удирдагч, үндэслэгчийн тогтоосон ёс суртахууны хэм хэмжээг дагаж мөрдөнө. Тэрхүү хэм хэмжээ нь тухайн улсын соёл, уламжлалт шашны ёс суртахууны хэм хэмжээнээс өөр байдаг.
3. Үндэслэгчийнхээ заасан шашны зан үйл, баяр ёслолд чухал ач холбогдол өгч тэмдэглэнэ. Тэдгээр зан үйл, баяр ёслол нь тухайн улсын түүх, соёл иргэншилтэй холбоотой баяр ёслолоос өөр бэлэгдэл, ач холбогдолыг заадаг онцлогтой.
4. Нийгмийн бүлэг үүсгэж буй шинэ шашны байгууллага нь шууд удирдагчийн хяналт, захиргаан дор үйл ажиллагаа явуулна. Өөрөөр хэлбэл шашны удирдагч, түүнийг тойрон хүрээлэгчдийн шийдвэр, зааврыг гишүүд нь үг дуугүй дагаж, захирагдана. Сүм, цуглаан, байгууллагын мөнгө санхүү, хандивыг зөвхөн удирдагч нь мэдэж, өөртөө ашигтайгаар зарцуулах эрх эдлэнэ.

Нийгэмд сөрөг нөлөө үзүүлдэг культээс сэргийлэхэд бүх нийтийн боловсролд анхаарч, тэдний шашны тухай мэдлэг, философи сэтгэлгээ, сэтгэл зүйн боловсролыг дээшлүүлэхэд шашин судлаач, философич, сэтгэл судлаач нар хамтран ажиллах хэрэгтэй байна.

Хүмүүс ихэнх нь шашны түүх, номлол сургаалын үзэл санаа, урсгал чиглэл, зан үйлийн нөлөө, шашны нийгэмд гүйцэтгэх үүрэг зэргийг мэдэхгүй, логик, нягтлан шинжлэх, оюун дүгнэлт хийх зэрэг философийн арга зүйн мэдлэг тааруу, ховсдолт, хайпервентиляци<sup>24</sup> (хэт түргэн, олон дахин гүнзгий амьсгаа авч, уушгиа хүчилтөрөгчөөр хэт дүүргэх нь хүний тархины үйл ажиллагаа, бие махбодид өөрчлөлтүүд авчирдаг байна), нөлөөлөл, гэмшил зэрэг сэтгэл судлалын мэдлэг сулаас болж, шинэ шашны хөдөлгөөн, культын хохирогч болж байна.

Аливаа шинэ шашны хөдөлгөөнд орохдоо хувь хүн доорхи гурван гол асуултыг тавьж, сөрөг хариулт давамгайлж байвал зайлсхийхийг зөвлөж байна.

**Нэгдүгээрт:** (Номлол сургаалын суурь үндэс, амьдралыг үзэх үзэл, гүн ухаан нь ариун, зөв эсэхийг анхаарна уу?) Энэ

шашны номлол сургаал хаанаас, ямар соёл иргэншлээс үүссэн, орчин үеийн шинжлэх ухаан, технологийн дэвшлийг үгүйсгэдэг эсэх, Монголын соёл иргэншилтэй харшлах эсэх, үндэслэгч нь үнэхээр үлгэр дууриалал болохоор ариун ёс суртахуунтай нэгэн мөн үү гэдгийг шинжилж үзэх нь дээр болов уу? Учир нь зарим гаж урсгалыг үүсгэн байгуулагчид нь уламжлалт гол шашны сүмээс үзэл бодол таарахгүй хөөгдсөн, сүмийн мөнгийг угаасан, татвараас зайлхийсэн, гэмт хэрэгт холбогдсон тохиолдлууд элбэг байдаг.

**Хоёрдугаарт:** (Үйл ажиллагаа нь зөв, ариун уу?) Шинэ шашны хөдөлгөөн нь шинээр гишүүн элсүүлэхдээ хууран мэхлэх, сүрдүүлж дарамтлах арга хэрэглэх тохилдол нилээн байдаг. Мөн ШШХ нь гишүүдээ захиргаадан дарангуйлах, айдаст автуулах, нийгмийн амьдралаас нь холдуулж идэвхгүй болгох, тэдний хөдөлмөрийг мөлжих, эд хөрөнгийг нь хандив болгож авах, бөөнөөр амиа хорлоход уриалах, нийгмийн эсрэг хорлон сүйтгэх, террорист үйл ажиллагааг АНУ, Япон, Африкийн бусад орнуудад явуулж байсан жишээ баримтууд байна. Тиймээс тухайн шашны зан үйл, үйл ажиллагаа нь Монгол улсын үндсэн хууль болон бусад хууль, тогтоолыг зөрчиж, хүний эрх чөлөө, нийгмийн эв нэгдэл, үндэсний аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлэх эсэхийг анхаарч үзнэ үү.

**Гуравдугаарт:** (Тухайн шашны урсгал хувь хүн танд болон Монголын нийгэм эерэг үр дагавар авчрах уу?) Тухайн шашны номлол сургаал, зан үйл, үйл ажиллагаа нь хувь хүн, нийгэмд, улс эх орны хөгжилд ямар үр дагавар авчирч болох вэ? гэдгийг сайтар тунгаан үзнэ үү. Зарим шинэ шашны хөдөлгөөн нь гишүүдээ гэр бүл, найз нөхөд, ажлын хамт олон, нийгмийн хүрээлэлээс нь хөндийрүүлж, ажил сургуулиас нь гаргаж байсан тохиолдлууд байдаг. Мөн зарим шинэ шашны хөдөлгөөн нь Монголчуудын төрөө дээдлэх үзлийг үгүй хийн төр засгийн шийдвэрийг үл хүндэтгэх, түүх, соёл уламжлалыг гутаан доромжлох, Монголчуудын уламжлалт баяр ёслолыг тэмлэглэхгүй байхыг уриалах, иргэний үүргээ биелүүлэхээс татгалзахыг гишүүддээ ятгах, нийгэмд итгэл үнэмшилээр нь хүмүүсийг хооронд талцуулж үл ойлголцол үүсгэх гэх мэт зохисгүй үйл ажиллагааг

<sup>24</sup> <http://www.healthline.com/symptom/hyperventilation>

явуулах нь улс орны үндэсний эрх ашигт хортой үр дагавар авчирч болох талтайг анхаарна уу.

**Дүгнэлт:** Монголын улсын үндсэн хуулинд монголчуудын аливаа шашин шүтэх, эс шүтэх эрхийг баталгаажуулж өгсөн ч зарим культ, шинэ шашны хөдөлгөөний нийгэмд үзүүлж болох сөрөг нөлөөг зогсоохын тулд засгийн газар болон судалгааны байгууллагууд олон нийтэд шинэ шашны хөдөлгөөн, культ, шашны бүлгүүдийн үйл ажиллагаа, гишүүнээ элсүүлдэг арга, тэдний номлол сургаалд буй ертөнцийг үзэх гүн ухааны үзлийн тухай мэдээлэлээр хангаж тэднийг оюун санаа, сүсэг бишрэлийн ухаалаг, зөв сонголт хийх боломжоор хангах нь чухал болоод байна.

Мөн эрх бүхий байгууллагууд шинэ шашны хөдөлгөөн, культийн талаар ямар нэг шийдвэр гаргаж, үйл ажиллагаа явуулахдаа өөрийн орны онцлог, түүх, соёл, уламжлалыг харгалзан үзэхээс гадна, өнөөдөр бид түүхийн ямар эрин үед амьдарч байгаа билээ, өнөөгийн нийгэм, улс төрийн хүчин зүйл, хууль эрх зүйн орчин нөхцөл, хувь хүний эрх чөлөөг харгалзан үзэх зайлшгүй шаардлагатайг анхаарах болжээ.

Энэхүү өгүүллээ бичихдээ гадаад дотоодын нэр алдар, ашиг хонжоо хайсан, өөрийгөө хэт дөвийлгэх үзэлтэй, сэтгэл мэдрэлийн өвчтэй, хуурмаг зальжин этгээдүүд хүний итгэл үнэмшлийг ашиглан шашны нэр барин тархи угаах, хүний бодол санааг хянаж өөрсдийн эрхшээлдээ оруулж болохыг сэрэмжлүүлэх зорилго тавьсан болно. Түүнээс ямар нэг шашны урсгалыг буруутгах зорилго тавьсангүй.

## НОМ ЗҮЙ

1. Д.Дагвадорж, М.Гантуяа, А. Жамбал, Шашин судлал (Эхлэн суралцах бичиг) УБ, 2001
2. С.Цэдэндамба, Монгол улс дахь шашины нөхцөл байдал, (XX-XXI зууны зааг үе) УБ, 2003
3. Монголын Эвангалын Эвсэл, “Таж Буруу Урсгалууд” товхимол, УБ, 2013
4. Andrew Eungi Kim, Characteristics of religious life in South Korea: A Sociological Survey, Korea University, Review of Religious Research, 2002, volume 43:4, page 293

5. John R. Hinnells, The Routledge companion to the study of Religion, NY, USA, 2005, page 330-331
6. Lorne L. Dawson, Cults and new religious movements, a reader, Blackwell publishing Ltd, MA, USA 2003
7. Malcolm Hamilton, The Sociology of Religion, Taylor & Francis group, UK, 2001 Pp229-272
8. Ralph W. Hood, Jr., Peter C Hill, Bernard Spilka, The Psychology of Religion (An empirical Approach), The Guilford press, NY, USA, 2009, 9, 259-287
9. Robbins, T. Cults, converts, and charisma. London, England: Sage, 1988.
10. Robert A Segal, The Blackwell companion to the study of Religion, MA, USA, 2006
11. Peter B Clarke, The Oxford Handbook of The Sociology of Religion, Online publication 2009
12. Saliba, John A., Understanding New religious Movements, 2nd ed. Walnut Creek, Calif: Alta Mira Press, USA 2003

## ЦАХИМ МАТЕРИАЛ:

1. Religious Movement Homepage Project,
2. <https://religionmongolia.wordpress.com>
3. [https://en.wikipedia.org/wiki/Margaret\\_Singer](https://en.wikipedia.org/wiki/Margaret_Singer)
4. [https://en.wikipedia.org/wiki/Cults\\_in\\_Our\\_Midst](https://en.wikipedia.org/wiki/Cults_in_Our_Midst)
5. <http://www.cesnur.org/default.htm>
6. <https://www.youtube.com/watch?v=8bRBFhMEQFk>
7. <https://www.youtube.com/>
8. [ch?v=zxJyfqaKU8&list=PLu3dHyvwbV69KYO\\_gCpLGR8191cLk\\_bc](https://www.youtube.com/watch?v=zxJyfqaKU8&list=PLu3dHyvwbV69KYO_gCpLGR8191cLk_bc)

## ABSTRACT

The article mentions the current Mongolian social and economic conditions and foreign, domestic circumstances of spreading the new religious movements in the country. It classified and clarified list of common names of new religious movements, which are functioning in Mongolian society and highlighted some negative effects, they might impact society. This writing based on American psychologist Margaret Singer's the study on the brain washing, mind control methods used by new religious movements.